

**ИХ БРИТАНИЙН НЭРТ МОНГОЛ СУДЛААЧ,
АКАДЕМИЧ ЧАРЛЬЗ БАУДЕНЫ АМЬДРАЛ,
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ**

Ж.Бат-Ирээдүй

Энэ 2014 онд Бритиш академийн жинхэнэ гишүүн, хүндэт профессор, нэрт монголч эрдэмтэн Чарльз Бауден гуайн мэндэлсний 90 насны ой тохиож байна. Монголчууд, монгол судлаач нар, монгол судлалынхан энэ хүний намтар түүх, ном бүтээлийн тухай энэ жил ярих учиртай. Тийм учраас МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэнгээс “Монгол судлалын шинэ чиг хандлага II” хурлыг түүний мэндэлсний тэгш ой буюу 90 насны ойд нь зориулан хийсэн билээ.

Завшаанаар үүнийг үгүүлэгч өчүүхэн миний бие 1991-1995 онд түүний удирдаж байсан Английн Лондоны их сургуулийн “Дорно дахин, Африкийн судлалын сургууль”-д зочин багшаар ажиллахдаа энэ хүнтэй нүүр тулан уулзаж, бас хамтран ажиллаж, байнгын харилцаатай, ойр дотно байх завшаан олсон юм. Түүний монгол-англи толь бичиг хийх явцдаа үгийн утга чанар асууж надад бичиж байсан олон арван захидал хадгалагдаж байгаа бөгөөд зөвхөн нэг захидлыг энд дуртган үзүүлэв.

Мөн Бауден гуай манай Л.Чулуунбаатар багшийг Лондоны Их Сургуульд багшилж байхад хамтарч ажиллаж байсан тухайгаа “Mongolian-English Dictionary” номынхоо оршилд бидний тухай¹ дурдан бичиж өгсөн нь өчүүхэн бидний хувьд том урам өгсөн аз завшаантай хэрэг болсон билээ. Мөн Л.Чулуунбаатар багш Ч.Бауден гуайн тухай “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”² өгүүллийг 2009 онд бичжээ.

Манайхан түүний 1968, 1989, 2002 онд хэвлүүлсэн «Орчин үеийн монголын түүх»-ийн ном, 1997 онд хэвлүүлсэн «Монгол - Англи толь бичиг»-ээр нь сайн мэдэх учиртай. Мэдээж монгол судлаачид бол бүгд түүнийг дэлхийд нэртэй ахмад эрдэмтэн хэмээн хүндлэн залбирдаг билээ.

Энэ өгүүлэлд³ Чарльз Бауден гуайн эрдэм судлалын ажлыг дүгнэх цэгнэх үнэлэх гэсэн зорилго тавьсангүй, харин монгол судлалын залуу халаа, залуу эрдэмтэн судлаач нарт түүний амьдрал, ажил үйлс, монгол судлалаар хийсэн эрдэм номынх нь их ажлын зах зухаас нь аль болох сонин содон талаас нь цухас боловч танилцуулахаар зорьсон юм.

Алдарт монголч эрдэмтэн Чарльз Бауден гуай 1924 оны 4 сарын 22 нд Английн зүүн урд зүгийн жижигхэн хот Вэймоут (Weymouth)-д төрж өссөн хүн. Тэрбээр 90 насыг зооглож байгаа ч бие тэнхлүүн, ухаан цэлмэг, эрдэм судлалын ажлаа үргэлжлүүлсээр Лондон хотын Хэйтров олон улсын нисэх буудлын ойролцоо амьдран сууж байна.

Түүний аав нь тухайн үеийн 5-14 настай хүүхдүүдийн сурдаг ерөнхий боловсролын сургуульд багш байсан бөгөөд яг тийм ижил төрлийн сургуульд хүүгээ сургажээ. Тэгээд 1941 онд азаар Кембрижийн их сургуулийн босгыг алхан оржээ. Тухайн үеийнхээ Оксфорд, Кембрижийн Их Сургуулиудад элсэн орсон анхны хүүхдүүдийн нэг байжээ. 1943 оны эхээр цэргийн албанд зарлан дуудах авахаасаа өмнө франц, герман хэл сурч байсан гэнэ.

Их сургуульд нэг жил гаруйхан болоод цэрэгт морджээ. Цэргийн алба хаших үедээ далайн цэрэгт алба хааж, япон хэлний курст суралцжээ. 1943 оны дундуур Шотланд руу цэрэгт шилжиж мөн япон хэлний 6 сарын дамжаанд суужээ. Үүний дараа албан хаагч болж Цейлонд япон хэлний орчуулагчаар явсан аж. Дайны сүүлийн жилүүдэд тэрбээр Хонг Конг, Японд хэдэн сараар алба хаан суужээ. Японд Хирошимагийн ойролцоох Күрэ гэдэг газарт алба хааж хэд хэдэн удаа тэнд зочилжээ.

Дайны үеийн туршлага түүнийг дорно дахиныг сонирхох сонирхолыг түрүүлсэн бөгөөд 1946 онд энгийн амьдралд шилжсэний дараа 1947 онд франц, герман судлалаар баклавын зэргээ хамгаалжээ. Үүний дараа

¹“I owe great debt of gratitude to Mr. L.Chuluunbaatar of SOAS and the State University of Mongolia for his generous help over a period of nearly two years in answering my questions and trying to remove my difficulties. In the last stages of the work I received help from his successor Mr.J.Bat-Ireedui. Needless to say, I alone am responsible for all remaining infelicities in the present work.” Charles R.Bawden, “Mongolian-English Dictionary”, Kegan Paul, 1997, I-II pp.

²Л.Чулуунбаатар, “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”, МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлал эрдэм шинжилгээний бичиг”, №30(318), 2009, 135-139 дэх тал

³Ж.Бат-Ирээдүй, “Монгол хэл бичиг: утга, соёл хэрэглээ”, Уб., 2013, 224-29 дэх тал

шууд л хятад хэл, хятад судлал сонирхож эхэлсэн бөгөөд энгийн албан хаагч болж засгийн газарт Английн гадаад яамны германы хэлтэст түр зуур ажиллажээ. 1948 онд ажлаасаа гарч Кембрижийн их сургуульдаа хятад судлалаар сурах болжээ. 1950-1951 онд мөн Хонг Конгод очиж хятад хэл сурч бүр Бээжин хот орохоор төлөвлөж байсан боловч Солонгосын дайнаас болж энэ хүсэл мөрөөдөл нь бүтэлгүйтэж буцаж ирээд 1952 оны эхэн хүртэл хятад судлалаараа ажиллажээ. Тэрбээр Унгар гаралтай Англид суурьшиж Кембрижийн Их сургуульд багш асан Д.Синорын сайн шавь байсан аж.

Энэ үеэс монгол судлал руу эргэлт буцалтгүй орсон гэж бүрэн хэлж болно. Энэ бол түүний амьдралдаа хийсэн том эргэлт байжээ. Учир нь тухайн үед тэрбээр дөнгөж гэрлэж, нэг хүүтэй болчихсон, амьдрал эхэлж байсан авч, Монголтой холбоотой ямар ч ажил алба байхгүй ийм үе байжээ. Мөн Монгол, Английн хооронд ямар ч харилцаа холбоогүй, бие биенээ маш бага мэддэг аль ч шугамаар харилцаа холбоо, судалгаа байдаггүй байсан үе байж. Тэрбээр «бидний хооронд дипломат харилцаа тогтоогүй, монголын эрдэмтэдтэй харилцах боломжгүй, тэдний нэрийг ч бараг мэддэггүй байсан. Монгол хэлийг Кембрижийн их сургуульд маш энгийн төвшинд заадгийг эс тооцвол өөр ямар ч сургалт байсангүй» гэж ярьж байсан.

Ингээд тэрбээр Кембрижийн их сургуулийн номын сангаас Өвөр Монголд хэвлэгдсэн Чингис хааны цадигийг олсон бөгөөд орчуулж, редакторлажээ. Сүүлд Б.Ринчен гуай түүнээс “та тийм сайн мэддэг номон дээрээ их цаг зарсаны учир юусан билээ” хэмээн асуухад нь Бауден гуай “үүнээс өөр үзэх юу ч байхгүй байсан юм чинь одоо өөр юу хийх вэ дээ” гэж хариулжээ. Түүний докторын зохиол нь 1955 онд «Монгол түүх бичлэгийн Алтан товч» нэртэй Германы Вейсбаденд хэвлэгджээ.

Доктороо хамгаалсны дараа нэг жил шахам ажилгүй суужээ. Азаар энэ үед Копенгагений их сургуулийн профессор К.Грөнбэх, Германы Гёттингений их сургуулийн др Вальтер Хайссиг нартай танилцахад тэд түүний ажлыг маш их сонирхжээ.

Др В.Хайссиг гуай түүний «Алтан товч»-ийг Гёттингений Азийн судлалын сэтгүүлд хэвлүүлэхээ амлаж, Грөнбэх Копенгагенд гурван сар ажиллаж Жавзандамба хутагтын намтарыг орчуулахыг санал болгожээ. Мөн Гёттингэнд “Алтан товч”-ийг хянах редакторлах ажлаар уригдсан байна. Энэ бол түүний «академик карьер»-ийн эхлэл нь байжээ.

Ч.Бауден гуай 1955 оноос Лондоны их сургуулийн Дорно дахин, африк судлалын сургуулийн дорно дахины салбарт багшаас ахлах багш, профессор болж улмаар 1968 оноос салбарын буюу Дорно дахины тэнхимийн эрхлэгчээр тасралтгүй 14 жил ажиллаж, 1982-1984 онд тус сургуулийн проректорын албыг хашиж байгаад тэтгэвэртээ гарсан билээ. Тэрбээр 1984 онд Лондоны их сургуулийн хүндэт профессор, 1985 онд Британийн Академийн гишүүнээр сонгогдсон юм.

1956 онд дайны өмнөхөн Өвөр Монголоос цуглуулсан эх бичиг, тэнд байх монгол номын каталоги хийх ажлаар Копенгагенд Грөнбэхтэй ажиллаж байж.

Ч.Бауден гуай анх 1958 онд тухайн үед Төв Азийг судлах хааны нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга, Английн хааны газарзүйн нийгэмлэгийн гишүүнээр олон жил ажилласан чөлөөнд гарсан ахмад Д.Смоолвууд гуайтай хамт Монголд ирсэнээр Монголтой хэлхээ холбоотой болж, эрдэмтэн судлаач нартай танилцжээ.

Монголын энх тайвны хорооны урилгаар ирсэн тэд хөдөө явж, монголын ахуй амьдралтай танилцаж үзээд, “энэ айлчлалд нэгээс хоёр коммунист биш барууныхныг багтаасан нь монголын тухай барууны ертөнцөд танилцуулах гэсэн зорилготой байсан байх» гэж тэрбээр ойлгожээ. Энэ аялал нь Британийн коммунист Игор Монтау гэдэг хүний хүчин чармайлтаар бүтсэн бөгөөд тэрбээр сүүлд «Хөх тэнгэрийн орон» ном бичсэн ажээ.

Тэр үед Монгол орноор 3 долоо хоног айлчлахдаа олон газар орон үзэж, Архангайн Цэцэрлэг, Өвөрхангайн Хужирт, Хархорин, мөн Налайхаар оржээ. Роберт Рупений «Монголчууд ба хорьдугаар зуун» номд смоолвууд, Роберт Рупен, Бауден гуай нарын Налайхын уурхайд хамт авахуулсан зураг байдаг юм байна билээ. Энэ удаагийн аялал судалгаа шинжилгээний чиглэлтэй байгаагүй ч тэрбээр академич Б.Ринчен, Х.Пэрлээ, Д.Сэр-Оджав, Т.Пагва нартай анх уулзаж танилцжээ.

Ч.Бауден гуай ер нь бол монгол хэлээр сүрхий зөв, эмх цэгцтэй сайн ярьдаг ярианы хэл бас их сайтай эрдэмтэн бөгөөд харин тухайн үед тэрбээр монгол хэлээр ярьж чаддаггүй байсан, Монголд англиар ярьдаг хүн ховор байсан учир Чогсом гэж франц хэлтэй зураач, герман хэлтэй зохиолч Д.Наваан-Юндэн нараар орчуулуулж байжээ. Буцах замдаа тэрбээр европоор дайрч Копенгагенд өөрийн каталоги хийсэн эх бичгийн хэдэн зуун микрофильмээ авч ашиглах эрхтэй болж энэ хэрэглэгдэхүүн дээрээ түшиглэн зурхай болон мэргэ төлөгийн судалгаа хийх бололцоотой болжээ. Мөн энэ сэдвээр Германы их сургуульд лекц уншиж, Азийн судлалын гол гол сэтгүүлд сайн сайн өгүүлэл нийтлүүлжээ.

Ч.Бауден гуайн Монгол Улсад хийсэн хоёр дах аялал нь 1959 онд болсон «Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хурал» байсан бөгөөд хуралд оролцохоор ирэх очих замдаа хоёуланд нь галт тэргээр аялжээ. Энэ хурлын үеэр монголч эрдэмтэн Оросын Ю.Н.Рерих, Г.Д.Санжеев, БНХАУ-ын Эрдэнэтөгтох, Чингэлтэй, Германы Поул Рачневский, Польшийн С.Калужински, Унгарын Урай Кохмали Каталан, Чехославакийн Павел Поуха, Италийн Пентти Аалто, Японы Г.Абэмацү, Озава Шигио, К.Сакамото, Энэтхэгийн Рагу Вира

нартай⁴ танилцжээ.

Тэрбээр 1968 он хуртэл монголд ирээгүй бөгөөд энэ хуртэл «Монголын орчин үеийн түүх» номоо бичиж байсан аж. Энэ үед монголын тухай мэдээлэл олж үзэхэд үнэхээр хүнд байжээ. 1962 онд Лондоны их сургуульд монголын тухай лекц уншихаар томилогдож 1970 онд профессор болжээ.

1968 оны намар өвлийг Монголд өнгөрөөсөн байна. Энэ үеэр хоёр удаа хөдөө явахаар төлөвлөж ШУА-ийн профессор Ж.Цолоо гуайтай хамт баруун аймгуудаар явсан байна. Энэ тухай Ж.Цолоо гуай “Хэл зохиолын хүрээлэнд хагас зуу илүү жил” номдоо “... Ховд аймгийн Буянт, Мянгад, Манхан суманд эрдэм шинжилгээний албан томилолтоор хагас сар ажилласан юм. Хүүхэд насаа өнгөрүүлсэн Зэрэгийн голд би Английн монголч эрдэмтэн Ч.Боудэн, сэтгүүлч А.Дашнямын хамт 1968 оны намар очиж хэд хонов. Бид гурав Зэрэг голын бригадын төв, хуучин хийдийн Шавар гэж нэршсэн сууринд Баясгалант амьдрал нэгдлийн 3-р бригадын контор, улаан буланд байрлаж Нусхай овогт 16 настай үлгэрч хүү Ганданповронгоос “Хүн долоон одны тухай үлгэр”, “Эзэн тэнгэр хаан тууль” сурвалжилж бичсэн болно. Мөн Зэрэг голын Наймдаан Шандад намаржиж байгаа тэмээчин Гүнчин Л.Баатарын зочилж, тэмээний хоормог анх удаа амтархан ууж, эмнэг булигиулж тоглуулахыг үзэв.”⁵ хэмээн бичжээ.

Мөн тэр намар Хөвсгөл руу явахаар төлөвлөж байсан боловч цаг агаарын байдлаас болж оронд нь Дархан явсан нь үзэх юмаар бага, сонирхолгүй байжээ. Бусад цагт нь улсын төв номын санд сууж гар бичмэл, эх бичгээ тагаж, хуулж, монгол ярианы хэлний дадлагын хичээлээ академийн Э.Вандуй гуайтай хийж байжээ.

«Тухайн үеийн нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас болж жирийн монгол хүмүүстэй уулзахад их төвөгтэй байсан. Улаанбаатар зочид буудалд амьдарч байхад намайг маш олон хүмүүстэй танилцахыг тасалдуулж, уулзах боломжгүй болгож байсан шүү» гэж тэрбээр надад хуучилж билээ.

1960-аад оны үеэс тэрбээр «Монгол-Англи толь бичиг»-ээ эхэлсэн бөгөөд маш их анхаарал тавьж тухайн үед Лондоны Их Сургуулийн Дорно дахин, Африкийн Сургуульд, сүүлд Бонны их сургуульд ажиллаж байсан Магадбүрэн Халтодтой хамтран ажиллаж байсан боловч шуудангаар харилцаж толь бичгийн ажил хийх машид төвөгтэй байжээ. Гэтэл 1978 оны 8 дугаар сард Магадбүрэн залууханаараа зуурдаар өөд болж түүний хийсэн зүйлүүд үрэгдэж толь бичгээ ганцаараа дуусгахаас өөр замгүй болжээ.

Энэ толь бол түүний монгол хэлшинжлэлд оруулсан томоохон хувь нэмэр, суурь судалгаа болох бөгөөд түүний 25 жилийн уйгагүй хөдөлмөр шингэсэн эрдэм шинжилгээний томоохон бүтээл болсон билээ. Уг толь бичигт хамгийн өргөн хэрэглэгддэг 3000 орчим үгийг шилж сонгон багтааж, толгой үгийн үүр, агуулгыг өнөөдөртөө лав ямар ч толинд байхгүй дэлгэрэнгүй хийсэн нь эрдэм шинжилгээ, практикийн маш чухал ач холбогдолтой болжээ. Мөн дэлхийн олон орны монгол судлаачид өндрөөр үнэлж маш сайн толь бичиг болсон гэж хэлж байхыг олонтоо сонсож байлаа.

Энэ он жилүүдэд тэрбээр шашин шүтлэг түүх, соёл, хууль ёсны тухай, газрын харилцааны тухай хэд хэдэн өгүүлэл, ном бичжээ. Тэрбээр 1978 оноос Английн Кристианы төлөөлөгчид Буриад Монголд (1818-1841) сэдвээр судалгаа хийсэн нь хамгийн сонирхолтой судалгаа байсан гэж өөрөө боддог юм билээ. Мөн бөөгийн шашны тухай хэд хэдэн томоохон өгүүлэл бичиж, “SHAMANS, LAMAS AND EVANGELICALS: THE ENGLISH MISSIONARIES IN SIBERIA” монограф хэвлүүлжээ. Бид түүний эрдэм шинжилгээний өгүүлэл⁶ бүтээлүүдээс өөрсдийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд цувралаар орчуулан хэвлүүлж, эрдэмтэн судлаач, ялангуяа залуу судлаачдын хүртээл болгоход анхаарч байгааг энд дурдалтай.

Хэл утга зохиолын чиглэлээр хийсэн бүтээлийн дотор 2003 онд Лондонд хэвлүүлсэн «Монголын уламжлалт уран зохиолын дээжис»⁷ (Anthology of Mongolian Traditional Literature) ном чухал байртай. Энэ номд 13- 19 дүгээр зууны монголын эртний уран зохиолыг англи хэлээр орчуулсан нь эрээд олдохгүй эрдэнэ, сураад олдохгүй сувд болсон билээ. Эл бүтээлд Монголын түүхтэй холбоотой аман яриа, түүх бичлэг, үлгэр домог, тууль, мөргөл залбирлын үг, шүлэг, бөөгийн дуудлага, ардын үлгэр, эртний уран зохиол, орчуулгын үлгэрүүд, ерөөл магтаал, дурсамж дуртгал, орчин үеийн уран зохиол хүртэл багтаж маш өргөн агуулгатай болсон юм.

1987 онд хуралдсан монголч эрдэмтдийн ээлжит их хуралд бэлтгэх ажлаар ШУА-ийн урилгаар 1986 онд гэргийтэйгээ айлчилсэн нь түүний хувьд суулчийн аичлал болоод байгаа ч бид Бауден гуайг дахин монголд морилоно гэдэгт итгэлтэй байна.

Профессор Бауден гуайн эрдэм судлалын бүтээлээс харахад тэрбээр монголын түүхийн эх сурвалж, эх бичиг судлалын шинжлэх ухааны суурь бүтээлээс эхлэн монголын эртний уран зохиол, толь бичиг судлал зэргийг сонирхон судалж байгаа нь түүний сэтгэлгээний цар хүрээ, оюун мэдлэг, эрдэм судлалын далайц хэчнээн өргөн, хэчнээн гүн болохыг нотлоно.

Түүний монгол судлалаар хийсэн хөдөлмөр бүтээлийг манай улс, төр засаг хүндэтгэн үнэлж Монгол Улсын “Найрамдал” медаль, Алтан гадас одонгоо хүртээжээ. Өвгөн профессорын маань хань нь хүнд өвчинд нэрвэгдэн дэргэдээс нь холдохын аргагүй болж тэрбээр олон он жил, цаг хугацааг ханиа асран халамжилахад

⁴ “Олон Улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал” I боть, Ш.Бира, Уб., 2009, 3 дах тал

⁵ Ж.Цолоо, “Хэл зохиолын хүрээлэнд хагас зуу илүү жил”, Уб., 2011, 160-64 дэх тал.

⁶ С. R. Bawden, “Remarks on some contemporary performances of epics in the MPR”, (орчуулсан Б.Мөнхцэцэг) МУИС-ийн МСХ-гийн “Acta Mongolica” сэтгүүл, №13 (385) 2013, 161-172 pp.

⁷ “Mongolian Traditional Literature an Anthology”, Selected and translated by Charles R. Bawden, Kegan Paul, London, 2003

зориулсан ч эрдэм номоо хийсээр, бүтээлээ туурвисаар монгол судлалыг үргэлжлүүлсээр байсан билээ.

Британийн монгол судлалын нэвтэрхий толь болж насан туршийн үнэнч ариун бүтээл хөдөлмөрөөрөө дэлхий дахины монголч эрдэмтэдийн дунд нэрт монголч эрдэмтэн хэмээх алдар хүндийг олсон Чарльз Бауден гуайн мэлмий тунгалаг, өлмий бат оршиж, эрдэм судлалын ажил улам дэлгэрч, урт насалж, шинэ шинэ бүтээл туурвилаараа хүндэтгэн бишрэгч биднийгээ гийгүүлж баясуулж явах өлзийтэй өрөөлийг энэ ялдам өргөн дэвшүүлж өчүүхэн энэ өгүүлэлээ төгсгөө.

НОМЗҮЙ

Ж.Бат-Ирээдүй, “Монгол хэл бичиг: утга, соёл, хэрэглээ”, Уб., 2013

Ch.R.Bawden, “Mongolian-English Dictionary”, Kegan Paul, 1997

C.R.Bawden, “Mongolian Traditional Literature an anthology” Kegan Paul, 2003

C.R.Bawden, “Remarks on some contemporary performances of epics in the MPR”, (орчуулсан Б.Мөнхцэцэг) МУИС-ийн МСХ-гийн Акта Монголика сэтгүүл, №13 (385) 2013, 161-172 pp.

“Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал”, Эрхлэн хэвлүүлсэн Ш.Бира нар, Уб., 2009

Ж.Цолоо, “Хэл зохиолын хүрээлэнд хагас зуу илүү жил”, Уб., 2011

Л.Чулуунбаатар, “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”, МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлал эрдэм шинжилгээний бичиг”, №30(318), 2009, 135-139 дэх тал